

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны . . . сарын . . . - ны өдрийн хуралдааны
. . . дугаар тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар,
Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-
ийн төслийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын
Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд, уг хэлэлцээрт
гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд олгох тухай Ерөнхий
сайдын захирамжийг ажлын шугамаар гаргахаар тогтов” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар ...

Гарын үсэг зурах эрх олгох тухай

"Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд олгосугай.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар,
Туркменистан Улсын Улсын Засгийн газар
хоорондын хэлэлцээр”-ийн төслийн тухай

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн яамны зүгээс агаарын тээврийн либералчлалыг дэмжиж агаарын харилцааг өргөжүүлэх, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, нислэгийн чиглэл, тоо, давтамжийг эрчимтэй нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Энэ хүрээнд агаарын тээврийн зах зээлийг Дундад Азийн бүс нутаг руу өргөжүүлэх зорилгоор Туркменистан Улсын Засгийн газартай агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, хэлэлцээрийн төслийг туркменистаны талтай эцэслэн тохирсон болно.

“Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл нь Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцод нийцүүлэн, хоёр орны нутаг дэвсгэрийн хооронд болон хилийн чанадад агаарын харилцаа тогтоох зохицуулалтыг тохирсон, олон улсын нийтлэг жишгээр үйлдсэн төсөл юм.

Хэлэлцээрийн төсөл нь нийт 26 зүйлтэй бөгөөд тээвэрлэлтийн эрх олгох, томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хууль тогтоомжийг хэрэглэх, шууд дамжин өнгөрөх нислэг, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, ашиглагчдад ногдуулах хураамж, гаалийн татвар болон бусад хураамжаас чөлөөлөх болон багтаамжийн зохицуулалт зэргийг тодорхойлсон. Мөн тариф, орлого гуйвуулах, арилжааны үйл ажиллагаа, аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт, статистик мэдээлэл, зөвлөгөөн, маргаан шийдвэрлэх, нэмэлт өөрчлөлт зэрэг зарчмын зохицуулалтуудыг тусгасан.

Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар хоёр улс хооронд шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалт бүрдэж, олон улсын тээвэр, логистикийн сүлжээнд холбогдож нислэгийн сүлжээг өргөжүүлэх, зорчигч урсгалыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг дэмжих, түүнчлэн Монгол, Туркменистан хоёр улсын харилцаа, худалдаа-эдийн засаг, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

АГААРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОН
ТУРКМЕНИСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар нь, (цаашид “Хэлэлцэн тохиролцогч Талууд” гэх)

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурж нээлттэй болсон Олон улсын иргэний нисэхийн Конвенцод нэгдэн орсон Хэлэлцэн тохиролцогч Талууд болохын хувьд,

Агаарын тээврийн компаниудын хоорондын зах зээлийн өрсөлдөөнд суурилсан олон улсын нисэхийн системийг хөгжүүлэхийг эрмэлзэн;

Олон улсын агаарын тээврийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн;

Худалдааг өргөжүүлэх, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах олон улсын агаарын тээврийн үр ашигтай, өрсөлдөх чадвартай арилжааны үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч;

Агаарын тээвэрлэгчдэд олон төрлийн үйлчилгээний сонголтыг нийт зорчигчдод санал болгох боломжийг олгох, мөн агаарын тээвэрлэгчдийг шинэлэг, өрсөлдөх чадвартай үнийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхийг дэмжихийг хүсэж; мөн

Олон улсын агаарын тээврийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг дээд зэргээр хангахыг хүсэж, агаарын хөлгийн аюулгүй байдалд заналхийлж буй үйлдэл, заналхийлэл нь хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдалд аюул учруулж, агаарын тээврийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, Иргэний Нисэхийн аюулгүй байдалд итгэх олон нийтийн итгэлийг сулруулдагт гүнээ санаа зовниж байгаагаа дахин нотолж;

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

ГАРЧИГ

Хэлэлцээрийн оршил

1 дүгээр зүйл	Тодорхойлолт
2 дугаар зүйл	Конвенцыг дагаж мөрдөх
3 дугаар зүйл	Тээвэрлэлтийн эрх олгох
4 дүгээр зүйл	Томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
5 дугаар зүйл	Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хязгаарлах
6 дугаар зүйл	Гаалийн татвар болон бусад хураамжаас чөлөөлөх
7 дугаар зүйл	Тариф
8 дугаар зүйл	Эрх хэрэгжүүлэх
9 дүгээр зүйл	Хууль тогтоомжийг хэрэглэх
10 дугаар зүйл	Үнэмлэх, гэрчилгээг хүлээн зөвшөөрөх
11 дүгээр зүйл	Даатгал
12 дугаар зүйл	Шударга өрсөлдөөн
13 дугаар зүйл	Нисэхийн аюулгүй ажиллагаа
14 дүгээр зүйл	Нисэхийн аюулгүй байдал
15 дугаар зүйл	Аяллын дугаар хуваан ашиглах
16 дугаар зүйл	Арилжааны үйл ажиллагаа
17 дугаар зүйл	Цагийн хуваарь
18 дугаар зүйл	Статистик мэдээллээр хангах
19 дүгээр зүйл	Олон талт хэлэлцээрүүдтэй нийцүүлэх
20 дугаар зүйл	Ашиглалтын хураамж
21 дүгээр зүйл	Байгаль орчныг хамгаалах
22 дугаар зүйл	Зөвлөлдөөн болон нэмэлт өөрчлөлт
23 дугаар зүйл	Маргаан шийдвэрлэх
24 дүгээр зүйл	Хэлэлцээр цуцлах
25 дугаар зүйл	Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бүртгүүлэх
26 дугаар зүйл	Хүчин төгөлдөр болох

ХАВСРАЛТ

1 дүгээр зүйл ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн, агуулгын хувьд өөрөөр заагаагүй бол:

(а) “Конвенц” гэж 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо байгуулсан Олон улсын иргэний нисэхийн Конвенц, энэхүү Конвенцын (90) дүгээр зүйлийн дагуу батлагдсан аливаа Хавсралт болон Конвенцын (90) болон (94) дүгээр зүйлийн дагуу Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулсан Хавсралт болон Конвенц, тэдгээрийг Хэлэлцэн тохиролцогч Талууд баталсан эсхүл соёрхон баталсан нэмэлт өөрчлөлтийг хэлнэ;

(б) “нисэхийн удирдах байгууллага” гэж Туркменистан Улсын Засгийн газрын хувьд Туркменистаны Сайд нарын танхимын дэргэдэх Тээвэр, харилцаа холбооны агентлагийн Туркменховаеллары агентлаг, Монгол Улсын Засгийн газрын хувьд Зам, тээврийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар эсхүл аль ч тохиолдолд энд дурдсан эрх бүхий байгууллагуудын хэрэгжүүлж буй чиг үүргийг гүйцэтгэх эрх хуулиар олгогдсон аливаа удирдах байгууллага эсхүл хүнийг хэлнэ;

(в) “тохиролцсон үйлчилгээ” гэж зорчигч, тээш, шууданг энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан маршрутаар тээвэрлэх олон улсын хуваарьт агаарын тээврийн үйлчилгээг хэлнэ;

(г) “томилогдсон агаарын тээвэрлэгч” гэж энэхүү Хэлэлцээрийн (4) дүгээр зүйлд нийцүүлэн томилогдсон болон тохиролцсон үйлчилгээ үзүүлэх эрх авсан агаарын тээвэрлэгчийг хэлнэ;

(д) “тодорхой маршрут” гэдэг нь энэхүү Гэрээний хавсралтад заасан маршрутыг хэлнэ;

(е) “багтаамж” гэдэг нь агаарын хөлгийн хувьд маршрутын дагуу тухайн агаарын хөлгийн боломжит ачаалаллыг мөн “тохиролцсон үйлчилгээ”-ийн хувьд ийм үйлчилгээнд ашиглаж буй агаарын хөлгийн тээвэрлэх боломжит багтаамжийг тухайн маршрутад эсхүл маршрутын хэсэгт энэ агаарын хөлгийн үйлдсэн нислэгийн давтамжаар үржүүлсэн тоог хэлнэ;

(ё) “нутаг дэвсгэр” гэж Улсын хувьд Конвенцын (2) дугаар зүйлд заасан утгыг илэрхийлнэ. Мөн “агаарын тээврийн үйлчилгээ”, “олон улсын агаарын тээврийн үйлчилгээ”, “агаарын тээвэрлэгч” болон “арилжааны бус зорилготой буулт” гэсэн тодорхойлолтууд нь Конвенцын (96) дугаар зүйлд заасан утгыг хэлнэ;

(з) “Тариф” гэж шуудан тээвэрлэхэд тогтоосон төлбөр болон нөхцөлөөс бусад зорчигч, тээш, болон ачаа тээвэрлэхэд төлөх болон эдгээр үнэ, хураамжийг хэрэглэх нөхцөлүүд, тээвэрлэлт хийхэд агентын үзүүлсэн үйлчилгээний төлбөр, агаарын тээвэрлэгчийн ийм тээвэрлэлтэд үзүүлсэн нэмэлт үйлчилгээний нөхцөлүүд;

(ж) “Хавсралт” гэдэг нь энэхүү Хэлэлцээрийн Хавсралтыг, түүний нэмэлт өөрчлөлтүүдтэй нь хамт хэлнэ. Хавсралт нь Хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд

өөрөөр заагаагүй тохиолдолд Хэлэлцээрийн бүх эшлэл хавсралтад хамаарах болно.

(и) “Газрын үйлчилгээний төхөөрөмж” гэдэг нь “агаарын хөлгийн агуулах ба нөөц сэлбэг” гэсэн нэр томъёо нь Конвенцын 9-р хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

2 дугаар зүйл КОНВЕНЦЫГ ДАГАЖ МӨРДӨХ

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд хамаарах Чикагогийн Конвенцын заалтуудад хамаарна.

3 дугаар зүйл ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЭРХ ОЛГОХ

1) Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хавсралтын Маршрутын хуваариар тогтоосон маршрутад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх эрх олгоно.

2) Энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл агаарын тээвэрлэгчид тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээг ашиглахын зэрэгцээ дараах эрхийг эдэлнэ:

а) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нь буулгүйгээр шууд дамжин нисэж өнгөрөх,

б) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нь арилжааны бус зорилготой буулт хийх,

в) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын тээвэр (зорчигч, ачаа тээш, шуудан) хослуулан эсвэл тусад нь авах, буулгах зорилгоор энэхүү гэрээний хавсралтад заасан маршрутын цэгүүдэд зогсолт хийх эрх.

3) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчигч, ачаа, шууданг хөлсөөр эсхүл арилжааны зорилгоор тохирсон нэг цэгээс Хэлэлцэн тохиролцогч Талын нөгөө цэг рүү тээвэрлэх эрх олгосон гэж ойлгохгүй.

4) Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн асуудал, эсхүл онцгой буюу ердийн бус нөхцөл байдлын улмаас Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч тухайн үйлчилгээг тогтоосон маршрутаар гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал тухайн үйл ажиллагааг нэн даруй үргэлжлүүлэхийн тулд маршрутын түр зуурын зохих зохицуулалт хийх талаар хүчин чармайлт гаргана.

4 дүгээр зүйл ТОМИЛГОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн нисэхийн удирдах байгууллага тохиролцсон үйлчилгээ явуулах зорилгоор нэг буюу хэд хэдэн агаарын

тээвэрлэгчийг томилох, тухайн аль нэг агаарын тээвэрлэгчийн нэрийг буцаах, өөрчлөх, эсвэл өмнө нь томилогдсон өөр агаарын тээвэрлэгчийг солих эрхтэй. Ийм тэмдэглэгээ, түүнд оруулсан өөрчлөлтийг тухайн агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Талын нисэхийн удирдах байгууллага бичгээр үйлдэж, дипломат шугамаар илгээнэ.

2. Томилогдсон агаарын тээврийн агаарын тээвэрлэгчийг томилох, солих, өөрчлөх тухай мэдэгдэл, өргөдлийн маягт дээр тогтоосон хэлбэр, журмаар хүлээн авмагц Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нислэг үйлдэх зөвшөөрлийг боломжит хамгийн бага хугацаанд, хойшлуулалгүй олгоно. Үүнд:

а) Агаарын тээвэрлэгчийг томилогч Тал эсхүл тухайн улсын харьяат этгээд эсхүл хоёулаа тухайн байгууллагын ихэнх хувийг өмчилдөг, түүнд үр дүнтэй хяналт тавих эрхтэй;

б) Томилогдсон агаарын тээвэрлэгчид өргөдөл, хүсэлтийг хэлэлцэн тохиролцогч Талаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд ихэвчлэн мөрддөг хууль тогтоомжийн дагуу тогтоосон нөхцөлийг хангах чадвартай; болон

в) Агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү Хэлэлцээрийн 13 дугаар зүйл (Нисэхийн аюулгүй ажиллагаа) болон 14 дүгээр зүйлд (Нисэхийн аюулгүй байдал) заасан стандартуудыг дагаж мөрдөж байх.

3. Агаарын тээвэрлэгчийг ийнхүү томилж, зөвшөөрөл авсан тохиолдолд энэ Хэлэлцээрийн 17 дугаар зүйлд (Цагийн хуваарь) заасны дагуу цагийн хуваарь тогтоосон тохиолдолд бүхэлд нь буюу хэсэгчлэн нислэг үйлдэж эхлэх боломжтой.

5 дугаар зүйл

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХЯЗГААРЛАХ

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчид олгосон үйл ажиллагааны зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгож, цуцалж, хязгаарлаж болно. Үүнд:

а) Тухайн агаарын тээвэрлэгчийн ихэнх хувийг өмчлөх, түүнд үр дүнтэй хяналт тавих нь тухайн агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Тал буюу түүний иргэдэд эсвэл хоёуланд нь үл хамаарах; эсвэл үндсэн зарчмын үйл ажиллагаа эрхлэх газар нь тухайн Талын нутаг дэвсгэрт байрладаггүй байх;

б) Томилогдсон агаарын тээвэрлэгч нь энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасан хууль, дүрэм журмыг мөрдөөгүй байх;

в) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь энэхүү гэрээний 13 дугаар зүйл (Нисэхийн ажиллагаа) болон 14 дүгээр зүйлд (Нисэхийн аюулгүй байдал) заасан стандартыг дагаж мөрдөөгүй, хэрэгжүүлээгүй байх.

2. Энэ зүйлийн 1b заалтыг зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд нэн даруй арга хэмжээ авах шаардлагагүй бол энэ зүйлд заасан эрхүүдийг нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын агаарын тээврийн байгууллагатай зөвшилцсөний дараа, Хэлэлцээрийн 22-р зүйлд (Зөвлөгөөн болон нэмэлт өөрчлөлт) заасны дагуу нисэхийн удирдах байгууллагуудын хооронд зөвлөлдсөний дараа хэрэгжүүлнэ.

3. Энэхүү зүйлийн 1 болон 2 дугаар заалтыг үл харгалзан, тус бүрийн Хэлэлцэн тохиролцогч Талууд онцгой нөхцөл байдал, онцгой үе эсвэл олон нийтийн аюулгүй байдлын үүднээс өөрийн нутаг дэвсгэр дээгүүр нисэх болон/эсвэл нисэх буудлууд дээр газардах эрхийг түр хугацаагаар хязгаарлах эрхтэй.

6 дугаар зүйл ГААЛИЙН ТАТВАР БОЛОН БУСАД ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨХ

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн Олон улсын агаарын тээврийн нислэг үйлдэж буй агаарын хөлөг болон агаарын хөлгийн үйлчилгээ хийхэд зориулсан байнгын тоног төхөөрөмж, сэлбэг, шатахуун болон тослох материал агаарын хөлгийн нөөц болон нислэгийн хугацаанд зорчигчдын хоол хүнс, уух зүйл болон тамхи Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нисэн ирэхэд байсан, нисэн явтал агаарын хөлгийн бүхээгт хадгалагдаж байсан нөхцөлд бүх гаалийн татвар, хяналт бүх төрлийн гаалийн татвар, хураамжаас чөлөөлнө.
2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэрт, эсхүл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн өмнөөс нэвтрүүлсэн, эсхүл тус томилогдсон агаарын хөлгийн бүхээгт шатахуун, тосолгооны материал, сэлбэг хэрэгсэл, байнгын тоног төхөөрөмж, агаарын хөлгийн хангамж болон зөвхөн олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглах зориулалттай эдгээр эд материал хангамжийн зүйл мөн түүнчлэн Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд аяллын үед ашиглах хангамжийг Хэлэлцэн тохиролцогч эхний Талын нутаг дэвсгэрт ногдуулсан гаалийн болон хяналт шалгалтын хураамж татвар, шимтгэлээс чөлөөлөгдөнө. Дээр дурдсан материалыг гаалийн хяналтад байлгахыг шаардаж болно.
3. Хэлэлцэн тохиролцогч аль ч Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт ердийн журмаар байх бүхээгийн байнгын тоноглол, хөлгийн бүхээг дэх эд материал, хангамжийн зүйл, шатахуун ба тослох материалын бүхээгийн нөөцийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зөвхөн энэ нутаг дэвсгэрийн гаалийн байгууллагын зөвшөөрлөөр хөлгийн бүхээгээс буулгаж болох бөгөөд эдгээр зүйлсийг гаалийн дүрэм журмын дагуу буцааж экспортлох, эсхүл өөр замаар ашиглаж дуусгах, устгах тэр цагийг хүртэл дурдсан эрх баригчдын хяналтын дор хадгална.
4. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэр дээгүүр шууд дамжин өнгөрч буй зорчигчид, тээш болон ачаа нь тухайн зориулалтын нисэх буудлын бүсээс гарахгүй тохиолдолд зөвхөн хуулиар тогтоосон хяналтад хамрагдана. Шууд дамжин өнгөрч буй тээш болон ачаа нь гаалийн татвар болон ижил төстэй бусад татвараас чөлөөлөгдөнө.
5. Агаарын тээвэрлэгчийн бэлгэ тэмдэг бүхий албан баримт бичиг нь харилцан нөхцөлтэйгөөр бүх төрлийн гаалийн татвар болон/эсвэл татвараас чөлөөлөгдөнө. Ийм баримт бичигт тээшний шошго, онгоцны тийз, ачааны тээврийн баримт, суудлын карт, хуваарь, албан тасалгааны болон газрын болон холбооны хэрэгсэл багтана. Эдгээр нь нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын томилогдсон агаарын

тээвэрлэгч зөвхөн өөрийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт оруулж ирсэн байх ёстой.

7 дугаар зүйл ТАРИФ

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилогдсон агаарын тээвэрлэгчдэд зах зээл дэх арилжааны бодлогод үндэслэн тариф тогтоохыг зөвшөөрнө. Хэлэлцэн тохиролцогч Талуудын хөндлөнгийн оролцоо нь дараах байдлаар хязгаарлагдана:

- а) Өрсөлдөгчийг хохироох, тухайн чиглэлээс өрсөлдөгчийг шахан гаргах зорилгоор ашиглах, эсвэл өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх тарифтай холбоотой үйлдлүүдийг хориглох;
- б) Давамгайл байр сууриа урвуулан ашиглаж үндэслэлгүй хэт өндөр эсхүл хязгаарласан тарифаас хэрэглэгчдийн хамгаалах; мөн
- в) Томилогдсон агаарын тээвэрлэгчдийг зохиомлоор хэт доогуур тогтоосон тарифаас хамгаалах.

8 дугаар зүйл ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгч нь Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт хөөрч, нөгөө Талын нутаг дэвсгэрт буух тохиролцсон үйлчилгээгээ явуулахад шударга, тэгш боломж олгоно. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрээс замд байгаа цэгүүд рүү, эсвэл замд байгаа цэгүүдээс Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчигчид суулгасан болон буулгасан тээврийг нэмэлт шинж чанартай гэж үзнэ. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч нь нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт зорчигчдыг суулгаж, тогтоосон маршрутын цэгүүдэд буулгах эсвэл зорчигчдыг тээвэрлэх багтаамжийг хангахдаа нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн энэ төрлийн тээврийн анхдагч ашиг сонирхлыг харгалзан үзэж, тэдний ашиг сонирхолд нөлөө үзүүлэхгүй байхыг харгалзана.

2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгчийн гүйцэтгэх тохиролцсон үйлчилгээ нь тогтоосон маршрутын дагуух олон нийтийн тээврийн хэрэгцээ шаардлагатай нягт уялдаатай байх бөгөөд уг үйлчилгээний үндсэн зорилго нь тухайн агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт зорчигч, тээш, ачаа болон шуудан тээвэрлэх эрэлтийг хангахуйц багтаамжийг хангахад чиглэгдэнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс зорчигч, тээш, ачаа болон шуудан тээвэрлэж, тогтоосон маршрутын дагуу гуравдагч улсын цэгүүдэд буулгах эсвэл эсрэгээр нь тээвэрлэх зохицуулалтыг дараах ерөнхий зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд багтаамж нь дараах хүчин зүйлстэй уялдаатай байна:

(а) Агаарын тээвэрлэгчийг томилсон Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт хөөрөх буюу буулгах тээврийн шаардлага;

(б) тухайн нутаг дэвсгэрт байрладаг муж улсын агаарын тээвэрлэгчдийн тогтоосон бусад агаарын тээврийн үйлчилгээг харгалзан агаарын тээвэрлэгчийн дайран өнгөрч буй бүсийн хөдөлгөөний шаардлага; болон

(в) Агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны эдийн засгийн үр ашиг, цар хүрээний шаардлага.

9 дүгээр зүйл ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭХ

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлж буй агаарын хөлгийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээсээ гаргах, эсхүл нутаг дэвсгэрт нь байгаа тухайн агаарын хөлгийн агаарын навигацитай холбогдох хууль тогтоомжийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгч баримтална.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын нутаг дэвсгэрт зорчигч, нисгэх баг, тээш, ачаа эсвэл шуудангийн нэвтрэх, дамжин өнгөрөх, түр саатах, нутаг дэвсгэрээс гарахтай холбоотой, нэвтрэх, гарах, иргэдийн шилжих хөдөлгөөн (паспортын хяналт), гааль, эрүүл мэнд, хорио цээрийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомж болон журам нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэгдэж буй зорчигч, нисгэх баг, тээш, ачаа эсвэл шуудангийн нэвтрэх, нутаг дэвсгэрээс гарах болон тухайн нутаг дэвсгэрт байх хугацаанд хэрэгжих болно.

3. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч энэ зүйлд заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ өөрийн орны агаарын тээвэрлэгчид, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид олгосноос илүү давуу эрх олгохгүй.

10 дугаар зүйл ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын дүрэм, журмын дагуу олгосон буюу хүчин төгөлдөр гэж үзсэн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эрхийн гэрчилгээ, үнэмлэхийн хүчинтэй хугацаанд эдгээр гэрчилгээ болон үнэмлэх нь Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай тэнцүү эсхүл түүнээс дээш төвшнийг хангасан нөхцөлд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэхүү хэлэлцээрт заасан маршрут болон тохиролцсон үйлчилгээ явуулахад хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэр дээгүүр нь эсхүл нутаг дэвсгэрт нь буух нислэгт зориулан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас эсхүл бусад улсаас өөрийнх нь иргэдэд нь олгосон эрхийн гэрчилгээ, үнэмлэхийг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхээ хадгална.

11 дүгээр зүйл ДААТГАЛ

Хэлэлцэн тохиролцогч Талуудын агаарын хөлөг, нисэхийн ажилтнуудын даатгал нь олон улсын жишгээр тодорхойлогддог бөгөөд хэлэлцээрт оролцогч талуудын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хийгддэг.

Ийм төрлийн зохицуулалтад оролцож буй бүх агаарын тээврийн байгууллагууд зохих зөвшөөрөлтэй байх ба нийтлэг мөрддөг шаардлагуудыг хангах.

Аливаа тийз борлуулсан тохиолдолд, энэ заалтын дагуу аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтад оролцож буй агаарын тээврийн байгууллага борлуулалт хийх үедээ нислэгийн хэсэг бүрд аль агаарын тээврийн байгууллага нислэг үйлдэхийг, мөн худалдан авагч ямар агаарын тээврийн байгууллага эсхүл байгууллагуудтай гэрээт харилцаанд орж байгааг тодорхой мэдэгдэх.

12 дугаар зүйл ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН

1. Өрсөлдөөний шударга орчин бүрдүүлэх, Хэлэлцэн тохиролцогч Талуудын агаарын тээврийн байгууллагуудад тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ эрхлэхэд нь өрсөлдөөний шударга, тэгш боломж олгох нь хамтарсан зорилт байна гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Талууд нотоллоо. Үүнээс үндэслэн Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ зорилтыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр энэхүү Хэлэлцээрт тусгагдсан эрхийг хэрэгжүүлэхээр өрсөлдөх боломжид сөргөөр нөлөөлөх алагчлах үзлийн бүх хэлбэр эсхүл шударга бус практикийг арилгах өөрийн хууль тогтоомжийн хүрээнд холбогдох бүхий л арга хэмжээг авна.
3. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн өрсөлдөөний тухай хууль тогтоомж, бодлого, практик эсхүл түүнд өөрчлөлт оруулах тэдгээр нь энэхүү Хэлэлцээрийн дагуу үйлдэгдэж буй агаарын тээврийн үйлчилгээнд нөлөөлөхөөр бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдэж, Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой Нисэхийн удирдах байгууллагуудын хариуцлагыг тодорхойлно.
4. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрийн хууль тогтоомж, зохицуулалтаар зөвшөөрсөн хэмжээнд өөрсдийн өрсөлдөөний тухай хууль тогтоомж болон бодлогын хэрэглээний талаар зөвлөмж өгөх байдлаар тус тусын агаарын тээврийн байгууллагад туслалцаа үзүүлнэ.
5. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал өөрийн томилсон агаарын тээврийн байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрээр зохицуулж буй агаарын тээврийн үйлчилгээг үзүүлэхэд шударга болон тэгш боломжид сөргөөр нөлөөлсөн эсхүл сөргөөр нөлөөлөхүйц ялгаварлан гадуурхал эсхүл шударга бус үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн гэж үзвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа Зөвлөгөөн хийх талаар хүсэлт хүргүүлж үл нийцэж буй асуудлын шалтгааны талаар мэдэгдэнэ. Хүсэлт хүргүүлснээс 15 хоногийн дотор Зөвлөгөөнийг хийнэ.
6. Хэлэлцэн тохиролцогч Талууд зөвлөлдөөнөөр асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал тус маргааны шийдвэрлэхээр энэхүү Хэлэлцээрийн 23 дугаар зүйлийн дагуу Маргаан шийдвэрлэх механизмыг ашиглаж болно.

13 ДУГААР ЗҮЙЛ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

1. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал, нисгэх баг, агаарын хөлөг, эсхүл тэдгээрийн аливаа үйл ажиллагаанд хамааруулан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал баталсан аюулгүй ажиллагааны стандартын асуудлаар зөвлөгөөн хийх хүсэлтээ хэдийд ч гаргаж болно. Ийм зөвлөгөөнийг хүсэлт гаргасан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор хийнэ.

2. Ийм зөвлөгөөний дүнд Хэлэлцэн тохиролцогч нэг Тал, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь дээрх салбаруудад аюулгүй ажиллагааны стандартыг наанадаж тухайн үед Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай тэнцүү тогтоон идэвхтэй мөрдөхгүй, зохион байгуулахгүй байгааг тогтоовол Хэлэлцэн тохиролцогч эхний Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа эдгээр дутагдлууд, наад захын стандартыг хангахад шаардлагатай гэж үзсэн алхмуудын талаар мэдэгдэх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал дутагдлаа засах зохих арга хэмжээ авна. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал зохих арга хэмжээг 15 (арван тав) хоног эсхүл тохиролцсон дагуу түүнээс их хоногийн дотор аваагүй бол энэ нь энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйл (Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хязгаарлах)-ийг хэрэглэх үндэслэл болно.

3. Конвенцын 33 дугаар зүйлд заасан үүргийг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч нэг Тал өөрөө эсхүл агаарын тээврийн байгууллагын нэрийн өмнөөс түрээсийн гэрээгээр, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү эсхүл нутаг дэвсгэрээс явуулж буй үйлчилгээндээ ашиглаж байгаа аливаа агаарын хөлөг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх үед нөгөө Хэлэлцэн тохиролцогч энэ Талын эрх бүхий төлөөлөгчид агаарын хөлөг бүхээгт, агаарын хөлгийн эргэн тойронд, агаарын хөлгийн болон нисгэх багийн бичиг баримт аль аль нь хүчинтэй эсэх, агаарын хөлгийн тухайн үеийн гадаад байдал, түүний тоног төхөөрөмжийг (энэ зүйлд "газар дээрх шалгалт" гэж нэрлэх.) үзэж шалгаж болно гэж тохиролцсон бөгөөд үзлэг шалгалт нислэгийг саатуулах үндэслэл болохгүй байвал зохино.

4. Газар дээрх нэг эсхүл хэд хэдэн удаагийн ийм хяналт шалгалтын үр дүнд:

a) Агаарын хөлөг эсхүл түүний үйл ажиллагаа нь тухайн үед Конвенцын дагуу тогтоосон наад захын стандартад нийцэхгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл; эсхүл

b) Тухайн үед Конвенцын дагуу тогтоосон аюулгүй ажиллагааны стандартыг идэвхтэй мөрдөхгүй, зохион байгуулахгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл, хяналт шалгалт явуулсан Хэлэлцэн тохиролцогч Тал, Конвенцын 33 дугаар зүйлийн зорилгод нийцүүлэн тухайн агаарын хөлөг түүнчлэн тухайн агаарын хөлгийн нисэх багт гэрчилгээ, үнэмлэх олгоход, эдгээрийг хүчин төгөлдөр гэж үзэхэд тавигдсан шаардлага эсхүл тухайн агаарын хөлгийг ашиглахад тавигдсан шаардлага нь Конвенцын дагуу тогтоосон доод захын стандартыг хангаагүй эсхүл стандартаас илүүгүй байна гэсэн дүгнэлтээ чөлөөтэй гаргах эрхтэй.

5. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын агаарын тээврийн байгууллагын өөрөө эсхүл агаарын тээврийн байгууллагын нэрийн өмнөөс ашиглаж буй агаарын хөлөгт энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу газар дээрх шалгалт хийх зорилгоор нэвтрүүлэхийг агаарын тээврийн энэ компанийн төлөөлөгч татгалзсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэ зүйлийн 4 дэх заалтад дурдсан ноцтой үндэслэл үүссэн гэж үзэж, дээрх заалтад дурдсан дүгнэлт гаргах эрхтэй.

6. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нэг эсхүл хэд хэдэн удаагийн газар дээрх шалгалтын үр дүн, газар дээрх шалгалт хийлгэхээр нэвтрүүлэхийг зөвшөөрөөгүй тохиолдол нь зөвлөлдөөн хийх, эсхүл өөр бусад байдлаар агаарын тээврийн байгууллагын аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах зайлшгүй шаардлага үүсгэсэн гэж дүгнэвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээврийн байгууллагад олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл өөрчлөх эрхээ хадгалж үлдэнэ.

7. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас энэ зүйлийн 2 дугаар эсхүл 6 дугаар заалтын дагуу авч хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээг, арга хэмжээ авсан үндэслэл байхгүй болсноор үргэлжлүүлэлгүй зогсоно.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

1. Олон улсын эрх зүйгээр хүлээсэн эрх үүргийнхээ дагуу, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хууль бус халдлагаас хамгаалахаар харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн болно гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Талууд дахин нотолж байна. Талуудын эрх, үүргийн нийтлэг байдлыг олон улсын эрх зүйн хүрээнд хязгаарлахгүйгээр Хэлэлцэн тохиролцогч Талууд 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо байгуулсан “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц”, 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо байгуулсан “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай Конвенц”, 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреаль хотноо байгуулсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай тухай Конвенц”, түүнд нэмэлт болгон 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Монреаль хотноо байгуулсан “Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүчирхийллийн хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай Протокол” болон Хэлэлцэн тохиролцогч Талууд гишүүнээр нэгдэн орсон нисэхийн аюулгүй байдлын тухай алив бусад конвенц, протоколын заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч Талууд хүсэлт хүлээн авмагц, иргэний агаарын тээврийн хөлгийг хууль бусаар булааж авах, иргэний агаарын хөлөг болон түүний зорчигч, нисгэх баг, нисгэх буудал, агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэл, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа бусад аюул заналаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л туслалцааг харилцан үзүүлнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөр хоорондын харилцаандаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон болон Конвенцод хавсралт болгон оруулсан, аюулгүй байдлын заалтууд, стандартууд, зөвлөмжүүдэд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна. Хэлэлцэн тохиролцогч Талууд нутаг дэвсгэртээ бизнесийн үйл ажиллагаагаа төвлөрүүлсэн эсхүл удирдлагын төв нь суурин байрладаг агаарын хөлөг ашиглагчид дээрх аюулгүй байдлын заалтуудыг дагаж мөрдөн ажиллахыг шаардана. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн үндэсний хууль, дүрэм журам, практик болон Конвенцын Хавсралтууд дахь нисэхийн аюулгүй байдлын стандартуудын хоорондох зөрүүг нөгөө Талдаа мэдэгдэнэ. Аль ч Хэлэлцэн тохиролцогч Тал ийм зөрүүг хэлэлцэхээр нөгөө Талаас шуурхай зөвлөлдөөн хийх хүсэлтээ хэдийд ч гаргаж болно.

4. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр агаарын хөлөг ашиглагчдаас Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү нэвтрэн орох, түүнээс нисэн гарах, нутаг дэвсгэрт нь байх үед дээрх 3 дугаар заалтад дурдсан нисэхийн аюулгүй байдлын заалтууд, шаардлагуудыг судалсан байхыг шаардахыг зөвшөөрнө. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэртээ агаарын хөлгийг хамгаалах, зорчигч, нисгэх баг, гар тээш, тээш, ачаа, агаарын хөлгийн нөөцийг агаарын хөлөгт зорчигчид авахаас өмнө, авах үед, эсхүл ачаа ачих үед шалгах зохих арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлнэ. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр тодорхой аюул заналын эсрэг аюулгүй байдлын зохистой тусгай арга хэмжээ авах тухай Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын аливаа хүсэлтийг нааштай хүлээн авна.

5. Иргэний агаарын хөлгийг хууль бусаар булаан авсан эсхүл булаан авах аюул занал учирсан, тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, зорчигчид, нисгэх баг, агаарын хөлөг, нисгэх буудал эсхүл агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн бусад хууль бус үйлдэл гарсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талууд дээрх үйлдэл эсхүл аюул заналыг шуурхай, аюулгүй байдлаар таслан зогсооход чиглэсэн холбоо барих болон бусад зүй зохистой арга хэмжээ авч харилцан тусалж ажиллана.

6. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нисэхийн удирдах байгууллагууддаа мэдэгдэл өгсний дараа 60 хоногийн дотор нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй аюулгүй байдлын арга хэмжээг агаарын хөлөг ашиглагчдын хүрээнд үнэлэх эрхтэй. Ийм үнэлгээг хийх захиргааны зохицуулалтуудыг нисэхийн удирдах байгууллагууд хоорондоо тохиролцож, үнэлгээг хурдан шуурхай явуулахад шаардлагатай арга хэмжээг яаралтай хэрэгжүүлнэ.

7. Хэлэлцэн тохиролцогч нэг Тал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаа энэ зүйлд дурдсан нисэхийн аюулгүй байдлын заалтуудыг хангахгүй байна гэж үзэх үндэслэлтэй бол эхний Хэлэлцэн тохиролцогч Тал зөвлөлдөөн хийх хүсэлтээ нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагад тавьж болно. Хэлэлцэн тохиролцогч талуудын аль нэг нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ийм зөвлөлдөөн эхэлнэ. Зөвлөлдөөн эхэлснээс хойш 30 хоногийн дотор тохиролцоонд хүрээгүй тохиолдолд, нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, эсвэл нэмэлт нөхцөл тавих үндэслэл болно. Онцгой нөхцөл байдлын улмаас эсхүл энэ зүйлийн заалтыг цаашид зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд эхний Хэлэлцэн тохиролцогч Тал хэдийд ч түр арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

15 ДУГААР ЗҮЙЛ

АЯЛЛЫН ДУГААР ХАМТРАН АШИГЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

1. Энэхүү тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээг үзүүлж буй болон үзүүлэх Хэлэлцэн тохиролцогч Тал бүрээс томилогдсон агаарын тээврийн байгууллагад аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтад дараах этгээдүүдтэй орж болно. Үүнд:
 - a) Нэг талын агаарын тээврийн байгууллага эсхүл тээвэрлэгчид;
 - b) Нөгөө талын агаарын тээврийн байгууллага эсхүл тээвэрлэгчид;

- с) Гуравдагч улсын агаарын тээврийн байгууллага эсхүл тээвэрлэгчид, тухайн гуравдагч улс нь нөгөө Талын агаарын тээврийн байгууллага болон бусад агаарын тээврийн байгууллагуудтай ижил төрлийн зохицуулалтуудыг тухайн гуравдагч улсын нутаг дэвсгэрээс болон нутаг дэвсгэр лүүгээ үйлчлэхийг зөвшөөрсөн эсхүл боломж олгосон тохиолдолд,

Ийм төрлийн зохицуулалтад оролцож буй бүх агаарын тээврийн байгууллагууд зохих зөвшөөрөлтэй байх ба нийтлэг мөрддөг шаардлагуудыг хангах.

Аливаа тийз борлуулсан тохиолдолд, энэ заалтын дагуу аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтад оролцож буй агаарын тээврийн байгууллага борлуулалт хийх үедээ нислэгийн хэсэг бүрд аль агаарын тээврийн байгууллага нислэг үйлдэхийг, мөн худалдан авагч ямар агаарын тээврийн байгууллага эсхүл байгууллагуудтай гэрээт харилцаанд орж байгааг тодорхой мэдэгдэх.

16 ДУГААР ЗҮЙЛ АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиогч Нөгөө талын томилогдсон агаарын тээврийн байгууллагуудад өөрийн нутаг дэвсгэрт олон улсын агаарын тээврийн үйлчилгээг худалдах, зах зээл бий болгох, түүнд холбогдох бусад бүтээгдэхүүнүүдийг худалдах боломжийг олгох бөгөөд цахимаар болон бусад хэлбэрээр борлуулалт хийн ажиллах өөрийн салбарыг байгуулах эрхийг олгоно.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээврийн байгууллагад менежер, техник, үйл ажиллагааны болон бусад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулахад шаардлагатай мэргэжилтэн, гадаад ажилтан албан хаагчаа Хэлэлцэн тохиролцогч тухайн улсын хууль тогтоомжийн дагуу, түүний нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, оршин суулгах, түүнд ажил олгох эрхтэй.
3. Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагад өөрийн нутаг дэвсгэрт агаарын тээврийн үйлчилгээг борлуулснаар олсон орлогыг зардлаас давсан хэмжээнд чөлөөтэй шилжүүлэх, хөрвүүлэх эрхийг ямар ч хязгаарлалтгүй, ялгаварлалгүйгээр, тухайн улсын валютын зохицуулалтын хууль, дүрмийн дагуу олгоно.

17 ДУГААР ЗҮЙЛ ЦАГИЙН ХУВААРЬ

Тохиролцсон үйлчилгээг нэвтрүүлэхээс эсвэл түүнд аливаа өөрчлөлт оруулахын өмнө аль болох урьдчилан 30 хоногоос багагүй хугацаанд, эсхүл нисэхийн удирдах байгууллагуудаас хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, Хэлэлцэн тохиролцогч Талын томилогдсон агаарын тээврийн байгууллага нь нөгөө Хэлэлцэн тохиролцогч Талын нисэхийн удирдах байгууллагад үйлчилгээний төрөл, цагийн хуваарь, нисэх онгоцны төрөл, тогтоосон чиглэл бүрд үзүүлэх багтаамж, мөн энэхүү Хэлэлцээрийн шаардлагыг зохих ёсоор мөрдөж байгааг батлахад шаардлагатай бусад мэдээллийг өгөх.

18 ДУГААР ЗҮЙЛ СТАТИСТИК МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

Хэлэлцэн тохиролцогч Талын нисэхийн удирдах байгууллага нь нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагын хүсэлтийн дагуу шаардлагатай гэж үзсэн статистикийн тогтмол болон бусад мэдээллээр хангана. Эдгээр мэдээлэл нь агаарын тээврийн дээрх компаниудын тохиролцсон үйлчилгээндээ гүйцэтгэсэн тээвэрлэлтийн тоо хэмжээ, эдгээр тээвэрлэлтийн эхлэл, төгсгөлийн цэгүүдийг тодорхойлоход шаардагдах бүх мэдээг агуулна.

19 ДУГААР ЗҮЙЛ ОЛОН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭРҮҮДТЭЙ НИЙЦҮҮЛЭХ

Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын хувьд агаарын тээврийн олон талын ерөнхий конвенц хүчин төгөлдөр болох тохиолдолд түүний заалтууд давамгайлах болно. Олон талын Конвенцын заалтын дагуу цуцлах, орлуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, олон талын Конвенцын заалтын дагуу хавсралт хийх асуудлыг тодорхойлох аливаа уулзалт хэлэлцээр энэхүү хэлэлцээрийн холбогдох заалтын дагуу хийгдэнэ.

20 ДУГААР ЗҮЙЛ АШИГЛАГЧДАД НООГДУУЛАХ ХУРААМЖ

1. Үйлчилгээ болон нисэх буудал бүрийн ашиглалт, түүний тоног төхөөрөмж, техникийн болон бусад байгууламж, үйлчилгээнд ногдуулах хураамж, түүнчлэн нислэгийн удирдлагын байгууламж, холбооны байгууламж, үйлчилгээнд ногдуулах бусад хураамжууд нь Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн тогтоосон тариф, үнэ тарифын дагуу ногдуулна.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээврийн компанид ногдуулах, эсхүл ногдуулахыг зөвшөөрсөн ашиглалтын хураамж нь олон улсын агаарын тээврийн ижил үйлчилгээ эрхэлж буй өөрийн агаарын хөлөгт ногдуулдаг хураамжаас ихгүй байна.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХАМГААЛАЛТ

Хэлэлцэн тохиролцогч Талууд нисэхийн тогтвортой хөгжлийг дэмжих замаар хүрээлэн буй орчныг хамгаалах хэрэгцээг дэмжинэ. Хэлэлцэн тохиролцогч Талууд тус тусын нутаг дэвсгэрийн хооронд үйлдэгдэх нислэгүүдийг Конвенцын Хавсралт 16 (Хүрээлэн буй орчны хамгаалалт)-ын Стандарт, санал болгосон зөвлөмжүүд болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон нисэхийн хүрээлэн буй орчныг хамгаалах тухай бодлого, удирдамжтай нийцүүлэхээр тохирлоо.

22 ДҮГЭЭР ЗҮЙЛ ЗӨВЛӨЛДӨӨН БОЛОН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

1. Хоёр Хэлэлцэн тохиролцогч Талууд, эсхүл тэдний нисэхийн удирдах байгууллагууд, энэхүү Хэлэлцээр болон түүний Хавсралтыг хэрэгжүүлэх, шаардлагатай заалтуудыг дагаж мөрдөхтэй холбогдуулан ойр хамтран ажиллах зарчмын дагуу, үе үе харилцан зөвлөлдөж ажиллана.
2. Энэхүү зөвлөлдөөн нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор эхлэх бөгөөд уг хугацааг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд харилцан зөвшөөрснөөр сунгаж болно.

3. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг өөрчлөх хүсэлтийг хэдийд ч нөгөө Талтай зөвлөлдөж болно.
4. Энэхүү Хэлэлцээрт оруулах нэмэлт өөрчлөлтийг тусдаа протокол хэлбэрээр боловсруулж, Хэлэлцээрийн салшгүй хэсэг болгон батална. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Хэлэлцээрийн 26 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөх болно.
5. Энэ заалтыг үл харгалзан, энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад багтсан Чиглэлийн Хуваарьт оруулах нэмэлт өөрчлөлтийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нисэхийн удирдах байгууллагуудын хооронд дипломат сувгаар харилцан бичгээр тохиролцох.

23 ДУГААР ЗҮЙЛ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд гарсан аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч Талууд нэн түрүүнд зөвлөлдөөн, хэлэлцээрийн замаар шийдэхийг эрмэлзэнэ.
2. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч Талууд хэлэлцээрийн замаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол, тэд маргааныг арбитрт шилжүүлэхээр тохиролцож болно, эсвэл аль нэг Хэлэлцэн тохиролцогч Талын хүсэлтээр уг маргааныг гурван арбитрчаас бүрдэх арбитрын шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно. Нэг арбитрчийг Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр нэр дэвшүүлж, гурав дахь арбитрчийг эхний хоёр арбитрчийн санал болгосноор томилно. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр маргааныг арбитрт шилжүүлэх тухай дипломат сувгаар мэдэгдэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор өөрийн арбитрчийг нэр дэвшүүлэх бөгөөд гурав дахь арбитрчийг дараагийн 30 хоногийн дотор томилно. Хэрэв аль нэг Хэлэлцэн тохиролцогч Тал тогтоосон хугацаанд арбитрчийг томилоогүй, эсхүл гурав дахь арбитрчийг томилж амжаагүй бол, аль нэг Хэлэлцэн тохиролцогч Талын хүсэлтээр Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгч арбитрч арбитрчдыг томилно. Ийм тохиолдолд, гурав дахь арбитрч нь гуравдагч улсын иргэн байх ба тэрээр шүүхийн даргаар ажиллаж, арбитрын хурал болох газрыг тогтооно. Хэрэв Ерөнхийлөгч уг маргааны талаар төвийг сахих боломжгүй улсын иргэн гэж үзвэл, энэ үүргийг гүйцэтгэх боломжтой ахлах дэд Ерөнхийлөгч томилгоог хийнэ. Арбитрын шүүх шийдвэрээ олонхын саналаар гаргана.
3. Арбитрын шүүхийн гишүүдийн зардлыг Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрсдөө хариуцна, харин гурав дахь арбитрчийн зардал болон бусад нийтлэг зардлыг Хэлэлцэн тохиролцогч Талууд тэнцүү хуваана.
4. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү зүйлийн (2)-т заасан аливаа шийдвэрийг дагаж мөрдөх үүрэгтэй.
5. Хэрэв аль нэг Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү зүйлийн (2)-т заасан шийдвэрийг биелүүлэхгүй бол, нөгөө Хэлэлцэн тохиролцогч Тал нь энэхүү Хэлэлцээрийн дагуу олгосон эрх, давуу эрхийг хязгаарлах, саатуулах эсхүл цуцлах эрхтэй.

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХЭЛЭЛЦЭЭР ЦУЦЛАХ

1. Аль нэг Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлээ, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр, дипломат шугамаар хэдийд ч өгч болно. Ийм мэдэгдлийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад нэгэн зэрэг өгнө.

2. Хэлэлцэн тохиролцогч Талууд тохиролцоонд хүрч Хэлэлцээр цуцлах мэдэгдлийг нэг жилийн хугацаа дуусахаас өмнө буцаан татаж аваагүй тохиолдолд, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал Хэлэлцээр цуцлах тухай мэдэгдэл илгээснээс хойш 12 сарын дараа Хэлэлцээр цуцлагдана. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал мэдэгдлийг хүлээн авсан тухайгаа нотлоогүй тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад уг мэдэгдлийг илгээснээс хойш 14 хоногийн дараа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал мэдэгдэл хүлээн авсанд тооцно.

25 ДУГААР ЗҮЙЛ ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭХ

Энэхүү Хэлэлцээр түүний хавсралт болон түүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бүртгүүлнэ.

26 ДУГААР ЗҮЙЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр Хэлэлцээр хүчин төгөлдөр болгоход шаардлагатай эрх зүйн дотоодын журмаа гүйцээснийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат ноот бичгээр мэдэгдсэнээр хойш 30 (гучин) хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

Энд өгүүлсэн зүйлийг батлан гэрчилж, өөрийн Засгийн газруудаас олгосон бүрэн эрхийн дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг хотод 2024 оны .. сарын ...-ны өдөр Туркмен, Монгол, Англи хэлээр тус бүр хоёр хувь байгуулсан бөгөөд бүх бичвэр ижил тэгш эрхтэй.

Хэлэлцээрийг тайлбарлахад ямар нэгэн зөрүү гарвал англи хэлээрх эхийг баримтална.

**ТУРКМЕНИСТАН УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

ХАВСРАЛТ 1
Маршрутын хуваарь

1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Туркменистан Улсаас томилогдсон агаарын тээврийн байгууллагын нислэг үйлдэх чиглэл:

Нислэг эхлэх цэгүүд	Дундын цэгүүд	Нисэн очих цэгүүд	Хилийн чанадах цэгүүд
Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд

Монгол Улсаас томилогдсон агаарын тээврийн байгууллагын нислэг үйлдэх чиглэл:

Нислэг эхлэх цэгүүд	Дундын цэгүүд	Нисэн очих цэгүүд	Хилийн чанадах цэгүүд
Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд	Хожим тодорхойлох цэгүүд

2 ДУГААР ХЭСЭГ

1. Дундын цэгүүд болон Хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэрийн чанад орших цэгүүдийг ямар нэгэн газарзүйн болон чиглэлийн хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжтой.
2. Агаарын үйлчилгээг гурав болон дөрөвдүгээр эрхийн хүрээнд гүйцэтгэнэ. Агаарын тээврийн 5 дугаар эрхийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын Нисэхийн удирдах байгууллагуудын хоорондын тусдаа тохиролцоогоор шийдвэрлэнэ.
3. Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын агаарын тээврийн томилогдсон компани/иуд аль нэг эсхүл бүх нислэгтээ тогтоосон маршрут дахь аливаа цэгийг алгасан, аливаа дарааллаар нисэж болох бөгөөд агаарын тээврийн компанийг томилсон Хэлэлцэн тохиролцогч тэр Талын нутгаас эхэлсэн, төгссөн байна.
4. Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ямар ч заалт нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын агаарын тээврийн байгууллагад нөгөө Талын нутаг дэвсгэр дотор, зорчигч, тээш, ачаа эсхүл шууданг хөлсөөр авч, тэндээс өөр цэг рүү тээвэрлэх эрх олгохгүй.
5. Зорчих цэг, нислэгийн давтамж, хүчин чадал, Хэлэлцэн тохиролцогч Талуудын томилогдсон агаарын тээврийн байгууллагын үйлчилгээнд ашиглагдах агаарын хөлгийн төрлийг хоёр талын Нисэхийн удирдах байгууллагууд хоорондоо тохиролцож шийдвэрлэнэ.

**AIR SERVICES
AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF TURKMENISTAN
AND
THE GOVERNMENT OF MONGOLIA**

TABLE OF CONTENTS

Contents	
	Preamble
Article 1	Definitions
Article 2	Applicability of the Convention
Article 3	Grant of Rights
Article 4	Designation of Airline and Operating Authorizations
Article 5	Revocation or Suspension of Operating Authorizations
Article 6	Exemption from Customs and other Duties
Article 7	Tariffs
Article 8	Exercise of Rights
Article 9	Application of Laws and Regulations
Article 10	Recognition of Certificates and Licenses
Article 11	Insurance
Article 12	Fair competition
Article 13	Aviation Safety
